



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 05 сарын 15 өдөр

Дугаар 217

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас
хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.1, 6.4.3 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 128 дугаар тогтоолын 5.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Өвөрхангай аймгийн Татварын хэлтсийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, сэргээн засварлах боломжгүй болсон, хоёр удаагийн нээлттэй дуудлагын худалдаагаар оролцогч ирээгүй тул 7,000,000.00 (долоон сая) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан 1 ширхэг автомашиныг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2.Татварын ерөнхий газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Занданбат, Өвөрхангай аймгийн Татварын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Н.Эрдэнэсүвд нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, сэлбэгээр ашиглах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Энэ тогтоолын биелэлтийн дүнг 2018 оны 2 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА


ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТСИЙН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Ц.НЯМ-ОСОР

Э.ЭРДЭНЭХИШИГ

0001778

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2018 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн
217 дугаар тогтоолын хавсралт



Өвөрхангай аймгийн Татварын хэлтсийн үндсэн хөрөнгөд
бүртгэлтэй акталж, данснаас хасах автомашин

Д/д	Автомашины марк, улсын дугаар, арал	Үйлдвэрлэсэн , ашиглалтад орсон огноо	Балансын үнэ (төгрөг)	ТӨБЗГ-ын 2017 оны 574 дүгээр тогтоолоор тогтоосон дуудлага худалдааны доод үнэ (төгрөг)	Сэлбэгээр худалдсанаас олох орлогын доод хэмжээ (төгрөг)
1	Ниссан санни, 18-88 ӨВР, арал №FB15817428	2004/ 2009	7,000,000.00	1,000,000.00	100,000.00
	Нийт дүн		7,000,000.00 (долоон сая)	1,000,000.00 (нэг сая)	100,000.00 (нэг зуун мянган)